



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (хуучин нэрээр)-ын хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,507,268,176.00 (нэг тэрбум таван зуун долоон сая хоёр зуун жаран найман мянга нэг зуун далан зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (2645 м.кв газар эзэмших)-ийг хашааны хамт Хүний эрхийн үндэсний комисст балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (хуучин нэрээр)-ын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Хунан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Газар эзэмших эрхийг шилжүүлж баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн
102 дугаар тогтоолын хавсралт



**Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын (хуучин нэрээр)
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй балансаас балансад
шилжүүлэх биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)**

д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 9 дүгээр хороо Э2203011116	2021	м.кв	2645	1,491,755,776.00
2	Хашаа /Сүхбаатар дүүргийн 9 хороо газрын/	2022	ш	1	15,512,400.00
Нийт дүн					1,507,268,176.00